

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.9. Аудитын илрүүлэлт.....	22
Залруулсан алдаа.....	22
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	22
Аудитын зөвлөмж.....	23
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	23
4. Менежментийн захидал	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/473
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Ашигт малтмал газрын тосны газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд, 3 бүлэг, 44 зорилт, 83 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлийг 91.0 хувьтай дээд шатны захирагчаар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,886,708,721.40	33,311,247,168.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	320,028,104.83
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	320,028,104.83
3121	Төгрөг	-	320,028,104.83
31211	Төрийн сангийн харилцах	-	320,028,104.83
33	АВЛАГА	9,084,000,275.03	9,248,680,688.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,099,023.99	
335	Бусад авлага	9,082,901,251.04	9,248,680,688.43
3351	Байгууллагаас авах авлага	9,078,015,410.80	9,248,680,688.43
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,885,840.24	
34	УРЬДЧИЛГАА	63,503,476.25	21,180,292.09
34600	Урьдчилж гарсан зардал	61,645,076.25	9,858,076.25
3471	Урьдчилгаа тооцоо	1,858,400.00	11,322,215.84
34714	Томилолтын урьдчилгаа	1,858,400.00	11,322,215.84
35	БАРАА МАТЕРИАЛ	563,814,616.84	545,967,729.50
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,579,290.00	30,925,195.00
354	Хангамжийн материал	559,235,326.84	515,042,534.50
35410	Бичиг хэргийн материал	14,778,837.66	7,227,725.09
35420	Аж ахуйн материал	521,580,050.97	478,541,504.14
35430	Сэлбэг хэрэгсэл	20,175,049.91	23,747,304.91
35440	Түлш, шатах тослох материал	2,701,388.30	5,526,000.36
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,433,420,746.69	5,623,648,475.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,433,420,746.69	5,623,648,475.95
391	Газар	208,169,615.00	208,169,615.00
392	Биет хөрөнгө	8,424,750,181.64	4,973,471,396.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,363,350,894.54	3,042,801,473.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(140,489,960.64)	(178,251,813.84)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,552,310,417.94	2,738,917,149.94
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,880,209,999.38)	(2,247,690,265.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,194,270,437.24	6,695,499,145.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,468,109,035.04)	(5,659,280,147.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,405,413,128.12	1,058,846,421.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,076,092,541.08)	(922,998,297.54)
39214	Бусад үндсэн хөрөнгө	968,005,278.87	940,674,575.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(493,698,438.93)	(495,046,845.75)
393	Биет бус хөрөнгө	37,800,500,950.05	442,007,464.26
39301	Програм хангамж	1,697,256,021.05	1,590,656,021.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,029,443,490.73)	(1,148,648,556.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,132,688,419.73	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	79,320,129,468.09	38,934,895,644.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	735,863,474.40	914,312,074.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	735,863,474.40	914,312,074.00
413	Өглөг	665,183,604.40	914,312,074.00
4136	Бусад өглөг	665,183,604.40	914,312,074.00
41361	Байгууллагад төлөх өглөг	626,145,138.00	914,312,074.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	33,721,033.99	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5,317,432.41	-
414	Урьдчилж орсон орлого	70,679,870.00	-
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	70,679,870.00	-

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>78,584,265,993.69</u>	<u>38,020,583,570.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	78,584,265,993.69	38,020,583,570.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,187,812,519.22	10,187,812,519.22
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	10,187,812,519.22	10,187,812,519.22
512	Хуримтлагдсан үр дүн	65,634,936,304.83	25,387,327,667.08
51210	Өмнөх үеийн үр дүн	66,246,931,968.23	65,951,010,090.69
51220	Тайлант үеийн үр дүн	(611,995,663.40)	(40,563,682,423.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,761,517,169.64	2,445,443,383.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>79,320,129,468.09</u>	<u>38,934,895,644.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	307,062,295,863.34	157,938,366,957.58
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,644,525,111.23	40,517,875,327.78
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,644,525,111.23	40,517,875,327.78
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	42,644,525,111.23	40,517,875,327.78
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	37,112,360,807.79	32,796,080,664.67
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	5,532,164,303.44	7,721,794,663.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	260,189,777,552.11	113,395,452,789.49
120	Нийтлэг татварын бус орлого	260,189,777,552.11	113,395,452,789.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,856,869,906.41	10,635,232,197.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,949,810,701.16	7,229,572,753.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,378,159,384.34	3,067,562,642.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	528,899,820.91	338,096,802.07
120006	Газрын тосны орлого	232,267,132,458.52	102,757,324,312.16
120009	Бусад орлого	65,775,187.18	2,896,279.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,227,993,200.00	4,025,038,840.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,851,543,200.00	4,025,038,840.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,851,543,200.00	4,025,038,840.31
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	376,450,000.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	376,450,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	307,674,291,526.74	158,455,714,333.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307,674,291,526.74	158,455,714,333.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,325,818,923.58	5,859,438,626.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,733,888,627.82	3,019,919,437.30
210101	Үндсэн цалин	1,453,693,879.35	1,388,598,441.07
210102	Нэмэгдэл	816,133,472.14	1,112,958,568.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	256,874,600.00	253,846,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	207,186,676.33	264,515,927.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	344,494,731.50	381,764,282.94
210201	Тэтгэврийн даатгал	301,867,508.34	326,481,121.02
210202	Тэтгэмжийн даатгал	11,197,587.13	14,524,321.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,510,069.56	11,098,656.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,083,597.22	2,696,380.70
210205	Эрүүл мэндийн даатгал	20,835,969.25	26,963,803.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,628,975.66	174,979,152.38
210301	Гэрэл, цахилгаан	23,026,234.92	25,290,693.54
210302	Түлш, халаалт	79,977,776.67	77,382,904.08
210303	Цэвэр, бохир ус	9,600,464.07	4,577,074.76
210304	Байрны түрээс	59,024,500.00	67,728,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	209,765,245.84	176,262,159.20
210401	Бичиг хэрэг	45,051,086.73	31,737,569.85
210402	Тээвэр, шатахуун	63,373,645.63	37,068,760.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,114,715.16	28,429,507.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	380,000.00	601,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,845,798.32	46,125,245.00
210408	Бараа материал акталсны зардал		32,300,076.10
2105	Нормативт зардал	725,120.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	725,120.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	132,312,064.13	78,915,992.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	1,864,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,042,200.00
210604	Урсгал засвар	131,992,064.13	75,009,292.91
2107	Томилолт, зочны зардал	320,455,143.11	52,488,868.52
210701	Гадаад албан томилолт	195,626,911.00	-
210702	Дотоод албан томилолт	122,978,232.11	52,488,868.52
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,850,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	651,456,799.23	753,979,656.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	573,263,748.03	630,893,123.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	2,120,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	32,545,732.00	41,746,014.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,713,401.00	5,643,019.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,040,200.00	1,394,552.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,436,710.20	62,664,440.40
210807	Газрын төлбөр	2,829,512.00	5,564,308.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,827,496.00	3,954,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,761,092,216.29	1,220,733,075.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,053,539.73	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,573,038,676.56	1,220,733,075.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,348,472,603.16	152,596,275,707.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,623,334,122.76	2,003,255,692.29
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,329,424,937.18	1,779,810,508.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	171,732,218.69	105,206,628.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	122,176,966.89	118,238,554.76
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	298,483,110,494.05	150,499,678,395.39
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,337,983.49	85,826,371.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	298,469,772,510.56	150,413,852,023.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	242,027,986.35	93,341,619.89
213404	Хөрөнгийн	242,027,986.35	93,341,619.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(611,995,663.40)	(517,347,375.99)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	40,046,335,047.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	40,014,079,834.89
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	32,255,212.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(40,046,335,047.62)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(611,995,663.40)	(40,563,682,423.61)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>305,110,085,872.54</u>	<u>157,993,790,682.03</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,644,525,111.23	40,517,875,327.78
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,644,525,111.23	40,517,875,327.78
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	42,644,525,111.23	40,517,875,327.78
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	37,112,360,807.79	32,796,080,664.67
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	5,532,164,303.44	7,721,794,663.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	258,180,789,103.12	113,328,868,053.67
120	Нийтлэг татварын бус орлого	258,180,789,103.12	113,328,868,053.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,775,336,789.50	10,537,622,461.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,911,911,658.85	7,470,059,819.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,863,425,130.65	3,067,562,642.04
120006	Газрын тосны орлого	232,267,132,458.52	102,757,324,312.16
120009	Бусад орлого	77,319,855.10	9,921,280.00
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/	61,000,000.00	24,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,284,771,658.19	4,147,047,300.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,851,543,200.00	4,113,750,840.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,851,543,200.00	4,025,038,840.31
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		88,712,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	433,228,458.19	33,296,460.27
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	433,228,458.19	33,296,460.27
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>306,374,709,068.54</u>	<u>157,645,405,577.20</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,374,709,068.54	157,645,405,577.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,865,495,238.27	4,402,307,189.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,813,735,068.53	2,791,388,597.58
210101	Үндсэн цалин	1,551,416,287.44	1,405,537,228.74
210102	Нэмэгдэл	816,133,472.74	783,854,730.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	256,874,600.00	291,660,908.71
210104	Урамшуулал	13,770,412.08	74,468,194.91
210105	Гэрээт ажлын хөлс	175,540,296.27	235,867,534.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	350,888,498.52	352,937,401.80
210201	Тэтгэврийн даатгал	255,586,898.52	245,608,911.80
210202	Тэтгэмжийн даатгал	23,825,400.00	25,972,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,060,300.00	20,777,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,765,100.00	8,634,190.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,650,800.00	51,944,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,468,975.66	174,979,152.38
210301	Гэрэл, цахилгаан	23,026,234.92	25,290,693.54
210302	Түлш, халаалт	79,977,776.67	77,382,904.08
210303	Цэвэр, бохир ус	9,600,464.07	4,577,074.76
210304	Байрны түрээс	78,864,500.00	67,728,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	205,662,058.24	150,232,369.41
210401	Бичиг хэрэг	42,263,238.08	28,732,437.01
210402	Тээвэр, шатахуун	67,345,400.00	40,047,944.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,614,715.16	28,429,507.40

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	380,000.00	601,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,058,705.00	52,421,481.00
2105	Нормативт зардал	1,386,000.00	1,706,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386,000.00	1,706,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	157,189,623.15	95,906,282.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,248,500.00	14,268,410.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,138,400.00	2,100,500.00
210604	Урсгал засвар	142,802,723.15	79,537,372.60
2107	Томилолт, зочны зардал	372,869,163.43	51,698,568.52
210701	Гадаад албан томилолт	212,017,011.00	-
210702	Дотоод албан томилолт	158,806,280.43	51,698,568.52
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,045,872.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	751,074,350.74	783,458,817.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	672,758,795.54	617,872,263.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	2,120,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	32,545,732.00	41,746,014.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,713,401.00	5,643,019.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,040,200.00	1,394,552.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,436,710.20	105,164,440.40
210807	Газрын төлбөр	2,829,512.00	5,564,308.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,950,000.00	3,954,220.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,509,213,830.27	153,243,098,387.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,584,830,989.85	2,293,879,306.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,323,902,837.18	1,780,140,508.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	138,751,185.78	138,187,661.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	122,176,966.89	375,551,136.02
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	298,605,118,954.32	150,828,877,461.39
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,346,443.76	415,025,437.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	298,469,772,510.56	150,413,852,023.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	319,263,886.10	120,341,619.89
213404	Хөрөнгийн	319,263,886.10	120,341,619.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1,242,041,196.00)</u>	<u>348,385,104.83</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	399,303,300.00	28,357,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	399,303,300.00	28,357,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	399,303,300.00	28,357,000.00
221001	Их засвар	3,560,300.00	-
222001	Тоног төхөөрөмж	130,786,300.00	20,877,000.00
223001	Бусад хөрөнгө	242,375,500.00	7,480,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	<u>22,851,200.00</u>	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(399,303,300.00)</u>	<u>(28,357,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,641,345,296.00)	320,028,104.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,641,345,296.00	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		320,028,104.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	66,246,931,968.23	79,196,261,657.09
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	66,246,931,968.23	79,196,261,657.09
Тайлант үеийн үр дүн			-611,995,663.40	-611,995,663.40
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	65,634,936,304.83	78,584,265,993.69
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	65,634,936,304.83	78,584,265,993.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-316,073,785.86	0.00	-316,073,785.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	65,634,936,304.83	78,584,265,993.69
Тайлант үеийн үр дүн			40,563,682,423.61	40,563,682,423.61
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,387,327,667.08	38,020,583,570.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,682,099,400.00	5,719,352,977.11	962,746,422.89	85.6
УРСГАЛ ЗАРДАЛ	6,682,099,400.00	5,719,352,977.11	962,746,422.89	85.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,881,453,800.00	3,796,367,206.67	85,086,593.33	97.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,543,749,200.00	2,540,728,624.93	3,020,575.07	99.9
Үндсэн цалин	1,771,795,200.00	1,390,744,791.02	381,050,408.98	78.5
Нэмэгдэл	593,409,000.00	783,854,730.29	(190,445,730.29)	132.1
Унаа хоолны хөнгөлөлт	123,436,800.00	291,660,908.71	(168,224,108.71)	236.3
Урамшуулал	55,108,200.00	74,468,194.91	(19,359,994.91)	135.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	345,208,300.00	326,036,315.71	19,171,984.29	94.4
Тэтгэврийн даатгал	243,458,500.0	224,286,515.71	19,171,984.29	92.1
Тэтгэмжийн даатгал	25,437,500.0	25,437,500.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	20,350,000.0	20,350,000.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	5,087,400.0	5,087,400.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	50,874,900.0	50,874,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,821,200.00	122,825,481.66	14,995,718.34	89.1
Гэрэл, цахилгаан	23,055,600.0	24,593,832.54	(1,538,232.54)	106.7
Түлш, халаалт	66,618,800.0	72,463,906.36	(5,845,106.36)	108.8
Цэвэр, бохир ус	25,919,300.0	4,167,742.76	21,751,557.24	16.1
Байрны түрээс	22,227,500.0	21,600,000.00	627,500.00	97.2
Хангамж, бараа материалын зардал	128,241,500.00	121,763,440.40	6,478,059.60	94.9
Бичиг хэрэг	29,391,400.0	28,477,150.00	914,250.00	96.9
Тээвэр, шатахуун	44,038,900.0	40,047,944.00	3,990,956.00	90.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,461,800.0	27,411,907.40	49,892.60	99.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	609,400.0	601,000.00	8,400.00	98.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,740,000.0	25,225,439.00	1,514,561.00	94.3
Нормативт зардал	1,206,000.00	1,202,000.00	4,000.00	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,206,000.0	1,202,000.00	4,000.00	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	40,494,800.00	21,328,110.00	19,166,690.00	52.7
Багаж, техник, хэрэгсэл	33,435,100.0	14,268,410.00	19,166,690.00	42.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,100,500.0	2,100,500.00	-	100.0
Урсгал засвар	4,959,200.0	4,959,200.00	-	100.0
Томилолт, зочны зардал	46,042,400.00	46,042,360.80	39.20	100.0
Дотоод албан томилолт	46,042,400.0	46,042,360.80	39.20	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	627,820,500.00	609,345,073.17	18,475,426.83	97.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446,883,600.00	443,758,519.50	3,125,080.50	99.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,772,000.00	2,120,000.00	652,000.00	76.5
Даатгалын үйлчилгээ	45,801,300.0	41,746,014.00	4,055,286.00	91.1
Тээврийн хэрэгслийн татвар	6,000,000.0	5,643,019.00	356,981.00	94.1

Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,500,000.0	1,394,552.00	105,448.00	93.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	114,413,400.0	105,164,440.40	9,248,959.60	91.9
Газрын төлбөр	6,400,000.00	5,564,308.00	835,692.00	86.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,050,200.00	3,954,220.27	95,979.73	97.6
Бараа үйлчилгээний бусад зардал	10,869,900.00	7,095,800.00	3,774,100.00	65.3
Бараа үйлчилгээний бусад зардал	10,869,900.00	7,095,800.00	3,774,100.00	65.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,800,645,600.00	1,922,985,770.44	877,659,829.56	68.7
Бусад урсгал шилжүүлэг	2,800,645,600.00	1,922,985,770.44	877,659,829.56	68.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,628,250,000.00	1,780,140,508.67	848,109,491.33	67.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	167,738,000.0	138,187,661.77	29,550,338.23	82.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,657,600.00	4,657,600.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,682,099,400.00	5,719,352,977.11	962,746,422.89	85.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,682,099,400.00	5,719,352,977.11	962,746,422.89	85.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,053,849,400.00	3,939,212,468.44	114,636,931.56	97.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,628,250,000.00	1,780,140,508.67	848,109,491.33	67.7
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	150	172	(22.00)	114.7
Удирдах ажилтан	104	104	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	46	46	-	100.0
Гэрээт ажилтан		22	(22.00)	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,005,190,518.81
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		1,005,190,518.81
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		605,939,982.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		161,360,980.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал		250,659,972.65
210101	Үндсэн цалин		14,792,437.72
210105	Гэрээт ажлын хөлс		235,867,534.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		26,901,086.09
210201	Тэтгэврийн даатгал		21,322,396.09
210202	Тэтгэмжийн даатгал		534,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		427,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал		3,546,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал		1,069,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		52,153,670.72
210301	Гэрэл, цахилгаан		696,861.00
210302	Түлш, халаалт		4,918,997.72
210303	Цэвэр, бохир ус		409,332.00
210304	Байрны түрээс		46,128,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал		28,468,929.01
210401	Бичиг хэрэг		255,287.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,017,600.00
210406	БҮТЭЗҮЙЛС		27,196,042.00
2105	Норматив зардал		504,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		504,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		74,578,172.60
210604	Урсгал засвар		74,578,172.60
2107	Томиллолт, зочны зардал		5,656,207.72
210702	Дотоод албан томилолт		5,656,207.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		167,017,944.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		167,017,944.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		370,893,536.02
2132	Бусад урсгал шилжүүлэг		370,893,536.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		370,893,536.02
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ		28,357,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		28,357,000.00
222001	Тоног төхөөрөмж		20,877,000.00
223001	Бусад хөрөнгө		7,480,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,325,218,623.64
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		1,291,922,163.37
12000421	Төлөөлөгчийг дэмжих сангийн орлого		1,291,922,163.37
	Кигам төсөл үлдэгдэл санхүүжилт		33,296,460.27
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		320,028,104.83

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд АМГТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд холбогдох хууль, журам, заавар хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор И.Эрдэнэцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

АМГТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 1/275 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго:

Ашигт малтмал, газрын тосны газар нь “Төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорилт, чиг үүрэг:

Тус газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт УИХ, ЗГ, УУХҮЯ-аас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахаас гадна холбогдох хууль, журмын биелэлтийг хангах зорилтуудын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Геологи хайгуулын салбарын чиглэлээр: Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хатуу, шингэн, хийн төлөвт ашигт малтмалын геологи хайгуулын судалгааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх зорилтын хүрээнд ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эрэл болон хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд хүлээн авч, бүртгэх;

2. Уул уурхайн салбарын чиглэлээр: тус салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд уулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, уулын болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянах, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, салбарын ААН-дийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэж, түүнд тулгуурласан судалгаа, санал, дүгнэлт боловсруулах;

3. Газрын тосны салбарын чиглэлээр: Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд тус салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой хангах, газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэх, үнийн судалгаа явуулах, дотоодын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгахад хяналт тавих;

4. Хүнд үйлдвэрийн чиглэлээр салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацын идэвхжилтийн судалгааг хийх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Хуулийн нэр	2020 онд нэмэлт, өөрчлөлт орсон огноо	2020 онд нэмэлт, өөрчлөлт орсон зүйл, хэсэг, заалтын дугаар
Төрийн албаны тухай хууль	2020-01-23	13.1.3
	2020-01-30	46.4
	2020-05-07	57.9, 57.10, 57.13
	2020-05-14	13.1.4, 13.1.6, 57.5.4
Газрын тосны тухай хууль	2020-05-01	37.1 - 37.3

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

АМГТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

УУХҮЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар харьяа АМГТГ-ын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

АМГТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ статистикийн хэлтсийн 2020 оны төлөвлөгөөний дагуу АМГТГ-ын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийж олон жил болсон авлага 8,334,066.9 мянган төгрөг болон Томас эйр ХХК-аас авах 9,858.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өгсөн байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ статистикийн хэлтсийн 2020 оны оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар батлагдсан төсөв, гүйцэтгэл, таван саяаас дээших худалдан авалтын мэдээллийг 4, 5, 6 дугаар саруудад нийт 13 удаа хугацаа хоцроож мэдээлсэн болон 6 сараас дээш урт хугацааны сургалт, өөрийн болон байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн зэрэг 20 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрснийг 2020 оны 12 дугаар сард шилэн дансанд нөхөж байршуулах, зөрчил арилгах зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулсан байна.

Тус газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 79,320,129.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,586,402.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

АМГТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,385,233.8 мянган төгрөгөөр буюу 49.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	320,028.1	320,028.1
Авлага	9,084,000.3	9,248,680.7	164,680.4
Урьдчилгаа	63,503.5	21,180.3	(42,323.2)
Бараа материал	563,814.6	545,967.7	(17,846.9)
Үндсэн хөрөнгө	46,433,420.7	5,623,648.5	(40,809,772.2)
Нөөцийн бараа	23,175,390.4	23,175,390.4	-
Нийт хөрөнгө	79,320,129.5	38,934,895.7	(40,385,233.8)
Өр төлбөр	735,863.5	914,312.1	178,448.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	78,584,266.0	38,020,583.6	(40,563,682.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	79,320,129.5	38,934,895.7	(40,385,233.8)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 320,028.1 төгрөг нь нэмэлт санхүүжилтийн дансанд төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих санхүүжилтээс хэмнэгдэн үлдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 9,248,680.7 мянган төгрөг болж 164,680.4 мянган төгрөгөөр өссөн нь сонгон шалгаруулалтын орлого 338,136.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 167,175.5 мянган төгрөгөөр хорогдсоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 8,334,146.9 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлоготой холбоотой уул уурхайн компаниудаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 545,967.7 мянган төгрөг болж 17,846.9 мянган төгрөгөөр буурсан. Бараа материалын дансны үлдэгдлийн 478,541.5 мянган төгрөг буюу 87.6 хувь нь хангамжийн материал байна.

Оны эцэст 10,155.6 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь төсвийг зохистой, хэмнэлттэй зарцуулахгүй байгааг харуулж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,623,648.5 мянган төгрөг болж 40,809,772.2 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд Монголын Үндэсний геологийн алба байгуулагдсантай холбоотой ажилтан албан хаагч болон 40,834,195.2 мянган төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь яамны хөрөнгө

оруулалтаар 94,265.1 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 88,575.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 405,454.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 40,834,195.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 208,169.6 мянган төгрөг болж, 37,132,688.4 мянган төгрөгөөр буурсан нь Монголын Үндэсний геологийн албанд геологийн холбогдолтой биет бус хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 914,312.1 мянган төгрөг болж 178,448.6 мянган төгрөгөөр өссөн нь сонгон шалгаруулалтын орлого 338,136.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 167,175.5 мянган төгрөгөөр хорогдсоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2020 оны барьцаа хөрөнгийн үлдэгдэл 329,199.1 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, нийт өр төлбөрийн 36 хувийг эзэлж байна.

Бусад 585,113.0 мянган төгрөгийн өр төлбөр нь 2015-2017 онуудад үүссэн цахим өргөдлийн үйлчилгээний хураамжийн төлбөр бөгөөд жил бүр хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдэд буцаан олгодог.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 38,020,583.6 мянган төгрөг болж 40,563,682.4 мянган төгрөгөөр буурсан нь балансаас баланст шилжүүлсэн хөрөнгийн анхны өртөг, элэгдлийн дүнгийн зөрүүгээс үүссэн гарз болон тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

АМГТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 149,123,928.9 мянган төгрөгөөр буюу 51.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 149,218,577.2 мянган төгрөгөөр буюу 51.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөн л татан төвлөрүүлэх шилжүүлгийн зардалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 316,073,785.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь шилжүүлсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүнээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,254,037.1 мянган төгрөг, сургалтын буцалтгүй тусламжийн орлогоос 1,457,477.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 7,711,514.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 465,521.6 мянган төгрөгөөр бууруулж 7,245,992.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,245,992.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,617,742.6 мянган

төгрөгийг улсын төсвөөс, 2,628,250.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Уг төлөвлөгөөнд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар АМГТГ-ын төсвийг 6,912,129.5 мянган төгрөгөөр баталж, 4,283,879.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,628,250.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр тодотгожээ.

Мөн 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 03/2194 тоот албан бичгээр АМГТГ-ын төсвийг 230,030.1 мянган төгрөгөөр бууруулж Монголын геологийн албыг санхүүжилтээр төсвийн зохицуулалт хийжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,053,849.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 4,025,038.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 28,810.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,775,640.5 мянган төгрөг, нийт 5,800,679.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,714,852.9 мянган төгрөгийг зарцуулж 85,826.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,714,852.9 мянган төгрөг буюу 85.5 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 14,955.7 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 19,166.7 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийн зардлыг 18,475.4 мянган төгрөгөөр, бусад зардлыг 3,774.1 мянган төгрөгөөр, хангамжийн материал худалдан авах зардлыг 6,478.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн өөрийн орлогын төлөвлөгөө 852,609.5 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлснээс шалтгаалан сургалтын урамшууллын зардал 848,109.5 мянган төгрөгийн зардал гараагүй байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ буюу үндсэн үйл ажиллагааны арга хэмжээнээс 78,187.4 мянган төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны арга хэмжээнээс 3,774.1 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын арга хэмжээнээс 334.2 мянган төгрөгөөр, зөвлөл, хорооны гишүүдийн арга хэмжээнээс 23.3 мянган төгрөг, ажилчдад олгох тэтгэмж урамшууллын арга хэмжээнээс 3,507.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 159,200,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150,413,852.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 5.5 хувиар дутуу биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Газрын тосны орлого	110,000,000.0	102,757,324.3	7,242,675.7	93.4
Ашигт малтмал хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр	30,000,000.0	32,715,352.6	(2,715,352.6)	109.1
Улсын төсвөөр хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	6,600,000.0	7,721,794.7	(1,121,794.7)	117.0
Бусад орлого	3,600,000.0	2,932,732.0	667,268.0	81.5
Өөрийн орлого/ Сонгон шалгаруулалтын орлого/	9,000,000.0	4,286,648.4	4,713,351.6	47.6
Нийт дүн	159,200,000.0	150,413,852.0	8,786,148.0	94.5

Газрын тосны борлуулалтын орлого нь бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 3 талбайгаас экспортолсон тосны орлого бөгөөд 2020 оны гүйцэтгэл 102,757,324.3 мянган төгрөг буюу 93.4 хувь байна.

Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 6.6 сая баррель буюу 897 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байснаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,107,479 баррель буюу 558,994 тонн түүхий тос олборлож, 4,064,129 баррель буюу 554,069 тонн түүхий тос БНХАУ руу экспортолсон. Олборлолтын төлөвлөгөөний гүйцэтгэл 62.2 хувь, экспортын төлөвлөгөөний гүйцэтгэл 61.6 хувьтай байна. Орлого тасрахад нөлөөлсөн хүчин зүйлүүд:

- Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр, 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор БНХАУ-ын иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улс руу нэвтрүүлэх хөдөлгөөнийг зогсоох тухай шийдвэр гарсан.
- 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Ковид-19 вирусын халдвар гарсантай холбогдон Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагааг явагдаагүй.
- Тосон-Уул XIX талбайн түүхий тосны экспортын үйл ажиллагааг 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс, Тамсаг XXI талбайн экспортын үйл ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сэргээж, онцгой нөхцөлд хязгаарлалттай тээврийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Тус хугацаанд 245.2 мянган тонн буюу 1,823.4 сая баррель газрын тос олборлон экспортолж боломжоо алдсан зэрэг шалтгааны улмаас орлого дутуу төвлөрүүлжээ.

Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох улсын төсвийн орлого бүрдүүлэх ажлын хүрээнд 2020 оны улсын төсөвт 9,000,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэл 4,286,648.4 мянган төгрөг буюу 47.6 хувь болж 4,713,351.6 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон хувилбар манай газарт 2020 оны 04 дүгээр сарын 02-ний өдрийн 03/904 албан тоотоор ирсэн.
- Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн а/40 дүгээр тушаалаар сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 9 талбайг олон нийтэд зарласан боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Улсын онцгой комиссоос гаргасан 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн а/47 дугаар тушаалаар хүчингүй болгосон.
- Мөн комиссын бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн а/204 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан.

Дээрх шалтгаануудын улмаас оны эхний 8 сарын байдлаар сонгон шалгаруулалт явагдаагүй, 9 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн сонгон шалгаруулалт явагдаж төсөвт 4,286,648.4 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого 1,291,922.2 мянга, кигам төсөл хөтөлбөрийн өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 33,296.5 мянга, нийт 1,325,218.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын зардалд 277,561.1 мянга, бараа, ажил үйлчилгээний зардалд 161,361.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжийн зардалд 167,017.9 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 370,893.5 мянга, хөрөнгийн зардалд 28,357.0 мянга нийт 1,005,190.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 320,028.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй харилцах дансанд үлдэгдлээр байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийг 130 удаа хандалт хийж 117 төрлийн мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ асуудлыг дотоод хяналт, шинжилгээ статистикийн хэлтсээс шалгалт хийж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 6 сараас дээш урт хугацааны сургалт, өөрийн болон байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн зэрэг 20 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрснийг 2020 оны 12 дугаар сард шилэн дансанд нөхөж байршуулах, зөрчил арилгах зөвлөмж өгч, зөрчлийг арилгуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 570.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5,560,369.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгснийг 79.9 хувьтай биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 24,221.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	570.2	1	570.2	0	0	100.0
Албан шаардлага	1	5,560,369.7	1	4,442,538.0	0	1,117,831.7	20.1
Зөвлөмж	1	24,221.2	1	24,221.2	0	-	100.0
Нийт дүн	3	5,585,161.1	3	4,467,329.4	0	1,117,831.7	20.1

/мянган.төг/

Өмнөх онд төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийг дээд шатны байгууллагаар батлуулж, зарцуулах гэсэн албан шаардлага өгснийг Уул уурхайн багц хуулийн төсөлд дэх Газрын тосны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын 2 дугаар зүйлд Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийг зарцуулах журмыг УУХҮЯ батлахаар заасан гэсэн тайлбар ирүүлсэн тул хэрэгжих шатандаа байгаа гэж үзэн

холбогдох байгууллагуудаар өөрийн орлогын төлөвлөгөөнд батлуулж, зарцуулах албан шаардлага өглөө.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,505,898.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 242,700.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 23,445.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1,239,752.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд барагдсаныг төсвийн гүйцэтгэлийн тайланд өөрийн орлогоор бүртгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгэх 242,700.0 мянган төгрөгийг хөрөнгийн олзоор бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,263,198.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 23,445.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,239,752.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулалгүйгээр 971,894.1 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4. "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх." 6.6.2. "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;" заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

2. Төлөөлөгчийг дэмжих орлогоос ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2 удаа тушаал гарган, үр дүнгийн урамшууллын хэлбэрээр цалингийн бүрэлдэхүүнд оруулж бүх ажилчдад шалгуур үзүүлэлтгүй 207,004.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3. Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн 50,698.6 мянга, шатахуун нөөцөлсөн 10,155.6 мянга нийт 60,854.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтууд, Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

4. Гэрээт ажилчдад нийгмийн асуудлыг дэмжих гэсэн тушаал гарган 21,245.7 мянган төгрөгийн, үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 55.1."Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ." 55.2. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг Засгийн газар батална." Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно" заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Барагдуулах төлбөрийн акт тогтоосон.

5. Тайлант онд Сити их сургуулийн спорт заалыг долоо хоногт 1 удаа, 2 цаг, 1 цагийн хөлс 100.0 мянган төгрөгөөр түрээслэхээр гэрээ байгуулж, гүйцэтгэлээс илүү 2,200.0 мянган төгрөгийн төлбөр шилжүүлж үрэлгэн зардал гаргасан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 168 тоот тогтоол холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Барагдуулах төлбөрийн акт тогтоосон.

Аудитын зөвлөмж

Аудитаар тухайн байгууллагад хэрэгжүүлж буй сургалтын урамшууллын арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журамд өөрчлөлт оруулах тухай зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх, төсөвт орлого бүрэн төвлөрүүлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 852,609.5 мянган төгрөгөөр, улсын төсвийн орлогыг 8,786,148.0 мянган төгрөгөөр тасалсан асуудалд анхаарал хандуулж орлогын төлөвлөгөөг биелүүлэх тал дээр үр нөлөөтэй ажил зохион байгуулах;

2. 2014-2015 онуудад улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүртгэл хөтлөн 12 байгууллагаас авах 8,334,146.8 мянган төгрөгийн авлага үүссэн, өмнөх оны аудитаар барагдуулах албан шаардлага өгсний дагуу тус байгууллага тодорхой арга хэмжээ зохион байгуулсан боловч авлагын дүн буураагүй, цаашид авлагыг барагдуулах талаар анхаарч ажиллах;

3. Нэмэлт санхүүжилтийн дансанд Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлогоос зарцуулаагүй үлдсэн 320,028.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн сангийн яам татан төвлөрүүлээгүй асуудлыг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар тодруулж авч үзнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу сургалтын урамшууллаас гадаадын их, дээд сургуульд оюутан тэтгэлгээр суралцуулах журмын дагуу 2018, 2019 оны сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутан 2020 онд гэрээ байгуулж, тэтгэлэгт хамруулсан нь
- 1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам заавар, зөрсөн байх;
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1."Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно." гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутнуудтай гэрээ байгуулах, сургалтын тэтгэлэг олгох асуудлыг тухайн жилдээ багтаан ажиллах, сургалтын урамшууллын тэтгэлгийг үр ашигтай байх талаар анхаарч гэрээнд өөрчлөлт оруулах;
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Анхаарч ажиллах хариу илүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	АМГТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021 /103/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ашигт малтмал, газрын тосны газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг холбогдох байгууллагаар төсөвт суулгаж батлуулаагүй зарцуулсан.	971,894.1	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
2	Төлөөлөгчийг дэмжих орлогоос ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2 удаа тушаал гарган, үр дүнгийн урамшуулал хэлбэрээр цалингийн бүрэлдэхүүнд оруулж бүх ажилчдад шалгуур үзүүлэлтгүй мөнгөн урамшуулал олгосон.	207,004.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
3	Гэрээт ажилчдад нийгмийн асуудлыг дэмжих гэсэн тушаал гарган үр дүнгийн урамшуулал олгосон.	21,245.7	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
4	МУЗГ-аас цар тахлын үед тэвчиж болох зарим зардлыг бууруулах, тус зардлаас орлого бүрдүүлэх чиглэл өгч 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 168 тоот тогтоол гаргасныг хэрэгжүүлж ажиллаагүй спорт заалны түрээсийн төлбөр шилжүүлсэн.	2,200.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
5	Сургалтын урамшууллаас 2018, 2019 оны сонгон шалгаруулалтад тэнцсэн оюутанд 2020 онд гэрээ байгуулж тэтгэлэг олгосон.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
6	Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн.	50,698.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
7	Шатахууны зардалд 10.2 сая төгрөг урьдчилж гарсан зардлаар шилжүүлж хэрэгцээ шаардлагаас илүү шатахуун худалдан авсан.	10,155.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
ДҮН		1,263,198.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 83/АО170122
СЭГ- 2021/103/СТЯ-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн 50,698,600.00/тавин сая зургаан зуун ерэн найман мянга зургаан зуу/ төгрөг, шатахуун нөөцөлсөн 10,155,600.00/арван сая нэг зуун тавин таван мянга зургаан зуу/ төгрөг, нийт 60,854,200.00/ жаран сая найман зуун тавин дөрвөн мянга нэг зуу/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, материал нөөцөлсөн зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 05 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

И.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 84/А0170122

Улаанбаатар хот

СЭГ-2021/103/СГА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулалгүйгээр 971,894,100.00/ есөн зуун далан нэгэн сая найман зуун ерэн дөрвөн мянга нэг зуу/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.6.2-д "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх";, 27 дугаар зүйлийн 27.1.7-д "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", 31 дүгээр зүйлийн 31.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана: 31.4.1.төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо; 31.4.2.төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлогыг сургалтын урамшууллын орлогын нэгэн ажил өөрийн орлогоор төсөвт батлуулж, зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

9006109

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R_Gazar86.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 85/АД/70122
СЯТ-2021/103/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөгчийг дэмжих орлогоос ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2 удаа тушаал гарган, үр дүнгийн урамшуулал хэлбэрээр цалингийн бүрэлдэхүүнд оруулж бүх ажилчдад шалгуур үзүүлэлтгүй 207,004,400.00/хоёр зуун долоон сая дөрвөн мянга дөрвөн зуу/ төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагч нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж ажилчдад цалин урамшууллын тушаал шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, биелэлтийг 2021 оны 05 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 25/АД/170122
САГ-2021/103/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид-19 цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмтэй үед долоо хоногт 2 удаа спорт заал түрээслэх гэрээ хийж, төлбөрийн 50 хувь болох 4,200,000.00/ дөрвөн сая хоёр зуу/ төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 168 дугаар тогтоолын 1-д "Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан зарим үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг хязгаарласан, зогсоосонтой холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны батлагдсан төсөвт бий болсон дараах арга хэмжээний санхүүжилт, зардлын хэмнэлтийг эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг хадгалах, иргэдийн амьжиргааг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай бусад арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан төсвийн зохицуулалт хийж зарцуулсугай:", 1.1-д "бүх шатны сургалтын үйл ажиллагаа, хурал семинар, баяр ёслол, урлаг спортын арга хэмжээний зарим зардал" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын


Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ашигт малтмал, газрын тосны газар нь тогтоол зөрчин гүйцэтгэлээс илүү шилжүүлсэн 2,200,000.00 /хоёр сая хоёр зуу/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

И.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 26/АОТ0122
САГ-2021/103/СТА-ТМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээт ажилчдад нийгмийн асуудлыг дэмжих тушаал гарган 21,245,700.00/хорин нэгэн сая хоёр зуун дөчин таван мянга долоон зуу/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1. "Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ." 55.2. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг Засгийн газар батална." Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ашигт малтмал, газрын тосны газар зориулалт бус зарцуулсан 21,245,700.00 /хорин нэгэн сая хоёр зуун дөчин таван мянга долоон зуу/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 26 horizontal dotted lines, spaced evenly down the page, providing a template for handwritten text.